



## ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төв аймгийн Батсүмбэр сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан

**Аудитын код:** ТӨА-2025/084/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер О.Амаржаргал Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор Ц.Саранчимэг Утас: 70273465 Цахим хаяг: saranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Ихмонгол хөлөг Аудит" ХХК Утас: 99061771 Цахим хаяг: info@imkaudit.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2025.02.25 № 01/150  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ТӨВ АЙМГИЙН БАТСҮМБЭР СУМЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА  
Б.НАНДИНЦЭЦЭГ ТАНАА

**Хязгаарлалттай санал дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Төв аймгийн Батсүмбэр сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Худалдан авсан хөрөнгө, материалын дүн нь бэлтгэн нийлүүлэгч байгууллагын төлбөрийн цахим системд бүртгэсэн төлбөрийн цахим баримтын дүнгээс зөрүүтэй, төлбөрийн цахим баримтын цахим системийн нэхэмжлэх дээр 21 байгууллагын үлдэгдлийг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй, Өмнөх оноос дамжсан их засварын үлдэгдлээр тайлагнасан 16,741.9 мянган төгрөгийн ажлыг гүйцэтгээгүй хугацаа хэтэрсэн, Томилолтын зардал, хоол унааны мөнгийг давхардуулан олгосон, 2 ажилтанд ээлжийн амралтын тооцоог 872.9 мянган төгрөгөөр илүү бодож олгосон зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний "Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" 2022 оны 05 дугаар тогтоолын дагуу олгогдож буй, үндсэн

412506440

мэргэжлийн тусламж үйлчилгээний 2024 оны 8-12 дугаар сарын 181,540.9 мянган төгрөгийн, нэг иргэнд ногдох нормативт зардлын 115,225.7 мянган төгрөгийн санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас олгоогүйн улмаас 296,766.6 мянган төгрөгийн төлбөртэй үйлчилгээний авлагын үлдэгдэлтэй байна.

#### **Аудитын гол асуудал**

Төв аймгийн Батсүмбэр сумын Эрүүл мэндийн төв нь тайлант хугацаанд гүйцэтгэсэн үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээний 480,595.7 мянган төгрөгийн орлогыг Эрүүл мэнд даатгалын ерөнхий газраас нэхэмжилсэн ба тус газрын хяналт баталгаажуулалтаар нэхэмжлэхийн дүнгээс хасагдсан 16,095.6 мянган төгрөгийн зөрчилтэй гүйлгээний дүнгээр тайлант оны орлогыг бууруулж тайлагнасан байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 39 зорилтын хүрээнд 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 85,0%-ийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>470,686,073.97</b>	<b>608,041,095.69</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	242,319,899.40	142,799,792.17
<b>312</b>	<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	242,319,899.40	142,799,792.17
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	242,319,899.40	142,799,792.17
31211	Төрийн сангийн харилцах	242,319,899.40	142,799,792.17
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	25,214,541.00	313,530,083.29
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	25,214,541.00	296,766,622.35
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	-	16,763,460.94
3351	Байгууллагаас авах авлага	-	16,763,460.94
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	46,664,000.00	-
34600	Урьдчилж гарсан зардал	46,664,000.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	156,487,633.57	151,711,220.23
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	81,707,095.02	68,700,181.43
35110	Тусгай зориулалттай материал	1,770,670.00	2,896,742.00
35130	Эм боох материал	79,936,425.02	65,803,439.43
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	74,153,688.55	82,404,188.80
35410	Бичиг хэргийн материал	823,518.00	1,588,360.00
35420	Аж ахуйн материал	727,000.00	1,008,200.00
35430	Сэлбэг хэрэгсэл	4,548,000.00	-
35440	Түлш, шатах тослох материал	1,387,500.00	322,500.00
35450	Барилгын засварын материал	8,088,942.00	2,182,100.00
35460	Хүнсний материал	394,719.34	571,350.00
35470	Бусад хангамжийн материал	58,184,009.21	76,731,678.80
35500	Биологийн хөрөнгө	626,850.00	606,850.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>488,981,786.13</b>	<b>668,323,138.54</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	488,981,786.13	668,323,138.54
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	479,757,369.69	646,167,471.98
39201	Барилга, байгууламж, орон сууц	402,608,579.13	490,403,791.13
39202	Хуримтлагдсан элэгдэл	(155,814,871.45)	(161,213,661.31)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	133,646,434.00	133,646,434.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(47,260,878.38)	(59,714,628.32)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	275,570,756.61	394,361,741.41
39206	Хуримтлагдсан элэгдэл	(151,778,871.52)	(197,768,556.33)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	38,077,305.01	44,300,305.01
39208	Хуримтлагдсан элэгдэл	(16,241,035.71)	(19,733,443.55)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	19,946,351.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(110,813.06)
39217	Ном	949,952.00	2,049,952.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	9,224,416.44	22,155,666.56
39301	Програм хангамж	950,000.00	950,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(789,583.56)	(858,333.44)
39303	Бусад биет бус хөрөнгө	9,064,000.00	22,064,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>959,667,860.10</b>	<b>1,276,364,234.23</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>972,061.58</b>	-
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	972,061.58	-
<b>413</b>	<b>Өглөг</b>	972,061.58	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	972,061.58	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>958,695,798.52</b>	<b>1,276,364,234.23</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	958,695,798.52	1,276,364,234.23
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	410,076,192.40	423,076,192.40
51101	Өмч: - төрийн	410,076,192.40	423,076,192.40

Төв аймгийн Батсүмбэр сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан

<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	403,524,437.88	708,192,873.59
51210	Өмнөх үеийн үр дүн	403,524,437.88	403,524,437.88
51220	Тайлант үеийн үр дүн	-	304,668,435.71
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	145,095,168.24	145,095,168.24
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>959,667,860.10</u></b>	<b><u>1,276,364,234.23</u></b>

## 2.2 Аудит хийсэн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,144,507,124.41</b>	<b>1,585,930,012.48</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>50,317,774.90</b>	<b>96,263,773.74</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>50,317,774.90</b>	<b>96,263,773.74</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	2,542,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	2,542,400.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого/Үндсэн хөрөнгө/	10,375,616.06	55,398,084.80
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого/Бараа материал/	39,942,158.44	38,323,288.94
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,094,189,349.51</b>	<b>1,489,666,238.74</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	-	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>17,419,780.98</b>	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,419,780.98	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>54,070,600.00</b>	<b>77,528,100.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	54,070,600.00	77,528,100.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>1,022,698,968.53</b>	<b>1,412,138,138.74</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,022,698,968.53	1,412,138,138.74
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,027,047,645.84</b>	<b>1,281,261,576.77</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,027,047,645.84</b>	<b>1,281,261,576.77</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,025,294,650.64</b>	<b>1,275,934,392.60</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>609,278,745.18</b>	<b>803,389,461.00</b>
210101	Үндсэн цалин	353,428,473.07	443,074,631.00
210102	Нэмэгдэл	185,058,057.12	288,802,469.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,378,240.88	5,922,480.00
210104	Урамшуулал	63,413,974.11	65,589,881.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>75,902,046.67</b>	<b>98,261,399.48</b>
210201	Тэтгэврийн даатгал	52,409,638.19	69,005,081.32
210202	Тэтгэмжийн даатгал	5,701,096.83	7,838,056.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,459,923.62	983,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,109,231.58	4,471,627.23
210205	Эрүүл мэндийн даатгал	11,222,156.45	15,962,834.49
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	-	-
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>57,734,922.58</b>	<b>69,634,554.25</b>
210301	Гэрэл, цахилгаан	9,646,459.78	7,211,296.90
210302	Түлш, халаалт	47,248,462.80	61,423,257.35
210303	Цэвэр, бохир ус	840,000.00	1,000,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>31,262,792.00</b>	<b>34,561,211.00</b>
210401	Бичиг хэрэг	3,118,392.00	3,305,601.00
210402	Тээвэр, шатахуун	20,586,700.00	22,353,690.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,984,400.00	2,406,220.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,573,300.00	6,495,700.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>165,376,122.31</b>	<b>172,951,661.48</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	149,291,513.65	156,287,452.14
210502	Хоол, хүнс	16,084,608.66	16,664,209.34
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,766,750.00</b>	<b>17,388,932.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,200,000.00	80,000.00
210604	Урсгал засвар	1,566,750.00	17,308,932.00

**Төв аймгийн Батсүмбэр сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан**

<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,978,000.00</b>	<b>2,724,800.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,978,000.00	2,724,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,280,561.00</b>	<b>3,729,598.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,408,708.00	2,457,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	576,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	130,000.00	130,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	86,928.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	78,925.00	80,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	486,598.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>78,714,710.90</b>	<b>73,292,775.39</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,630,649.34	5,778,580.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	65,084,061.56	67,514,195.39
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,752,995.20</b>	<b>5,327,184.17</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,619,342.00</b>	<b>-</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,619,342.00	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>133,653.20</b>	<b>5,327,184.17</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	133,653.20	5,327,184.17
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>117,459,478.57</b>	<b>304,668,435.71</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>251,387.56</b>	<b>-</b>
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	251,387.56	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>251,387.56</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>117,710,866.13</b>	<b>304,668,435.71</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгаар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,068,974,808.51</b>	<b>1,220,656,557.39</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>2,542,400.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	2,542,400.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	-	2,542,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	2,542,400.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>54,070,600.00</b>	<b>77,528,100.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	54,070,600.00	77,528,100.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>997,484,427.53</b>	<b>1,140,586,057.39</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	997,484,427.53	1,140,586,057.39
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>991,778,917.77</b>	<b>1,171,641,341.62</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>991,778,917.77</b>	<b>1,171,641,341.62</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>990,025,922.57</b>	<b>1,166,314,157.45</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>608,650,124.62</b>	<b>802,333,379.00</b>
210101	Үндсэн цалин	352,799,852.51	443,074,631.00
210102	Нэмэгдэл	185,058,057.12	287,746,387.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,378,240.88	5,922,480.00
210104	Урамшуулал	63,413,974.11	65,589,881.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>76,179,904.67</b>	<b>99,339,082.42</b>
210201	Тэтгэврийн даатгал	52,310,262.19	70,082,764.26
210202	Тэтгэмжийн даатгал	6,078,330.83	7,838,056.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,459,923.62	983,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,109,231.58	4,471,627.23
210205	Эрүүл мэндийн даатгал	11,222,156.45	15,962,834.49
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>52,088,946.80</b>	<b>70,606,615.83</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,157,984.00	8,183,358.48
210302	Түлш, халаалт	47,248,462.80	61,423,257.35
210303	Цэвэр, бохир ус	682,500.00	1,000,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>32,449,675.00</b>	<b>34,597,433.00</b>
210401	Бичиг хэрэг	3,013,050.00	4,022,623.00
210402	Тээвэр, шатахуун	21,659,225.00	21,288,690.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,059,400.00	2,441,220.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,718,000.00	6,844,900.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>137,011,602.50</b>	<b>126,906,379.20</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	120,918,874.50	110,065,539.20
210502	Хоол, хүнс	16,092,728.00	16,840,840.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>58,652,475.00</b>	<b>15,464,090.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,559,900.00	2,540,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,914,200.00	6,090,000.00
210604	Урсгал засвар	52,178,375.00	6,834,090.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,978,000.00</b>	<b>2,724,800.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,978,000.00	2,724,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,049,853.00</b>	<b>3,729,598.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,404,000.00	2,457,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	576,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	130,000.00	130,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	86,928.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	78,925.00	80,000.00

Төв аймгийн Батсүмбэр сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	486,598.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>20,965,340.98</b>	<b>10,612,780.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,965,340.98	10,612,780.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	<b>28,815,400.00</b>	<b>148,535,323.00</b>
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(28,815,400.00)</u></b>	<b><u>(148,535,323.00)</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>48,380,490.74</b>	<b>(99,520,107.23)</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	193,939,408.66	242,319,899.40
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	242,319,899.40	142,799,792.17

**2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	-	-	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	-	-	-	-	-
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	-
D01	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>410,076,192.40</b>	<b>145,095,168.24</b>	<b>403,524,437.88</b>	-	<b>958,695,798.52</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>410,076,192.40</b>	<b>145,095,168.24</b>	<b>403,524,437.88</b>	-	<b>958,695,798.52</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	13,000,000.00	-	-	-	<b>13,000,000.00</b>
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	304,668,435.71	-	<b>304,668,435.71</b>
D09	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>423,076,192.40</b>	<b>145,095,168.24</b>	<b>708,192,873.59</b>	-	<b>1,276,364,234.23</b>

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан**  
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	242,319,899.40	(242,319,899.40)	-
<b>I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,716,975,400.00</b>	<b>1,314,849,480.45</b>	<b>402,125,919.55</b>	76.6
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,716,975,400.00	1,314,849,480.45	402,125,919.55	76.6
Бараа, үйлчилгээний зардал	1,716,975,400.00	1,314,849,480.45	402,125,919.55	76.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	986,836,200.00	802,333,379.00	184,502,821.00	81.3
Үндсэн цалин	521,472,000.00	443,074,631.00	78,397,369.00	85.0
Нэмэгдэл	338,403,700.00	287,746,387.00	50,657,313.00	85.0
Унаа, болон бусад нөхөн олговор	8,064,000.00	5,922,480.00	2,141,520.00	73.4
Урамшуулал	118,896,500.00	65,589,881.00	53,306,619.00	55.2
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>119,044,200.00</b>	<b>99,339,082.42</b>	<b>19,705,117.58</b>	<b>83.4</b>
Тэтгэврийн даатгал	83,626,100.00	70,082,764.26	13,543,335.74	83.8
Тэтгэмжийн даатгал	9,838,400.00	7,838,056.44	2,000,343.56	79.7
ҮОМШӨ ний даатгал	983,800.00	983,800.00	-	100.0
Ажилгүйдлийн даатгал	4,919,200.00	4,471,627.23	447,572.77	90.9
Эрүүл мэндийн даатгал	19,676,700.00	15,962,834.49	3,713,865.51	81.1
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>75,628,100.00</b>	<b>70,606,615.83</b>	<b>5,021,484.17</b>	<b>93.4</b>
Гэрэл цахилгаан	12,410,800.00	8,183,358.48	4,227,441.52	65.9
Түлш, халаалт	61,417,300.00	61,423,257.35	(5,957.35)	100.0
Цэвэр, бохир ус	1,800,000.00	1,000,000.00	800,000.00	55.6
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>81,562,700.00</b>	<b>34,597,433.00</b>	<b>46,965,267.00</b>	<b>42.4</b>
Бичиг хэрэг	5,502,200.00	4,022,623.00	1,479,577.00	73.1
Тээвэр (шатахуун)	59,501,900.00	21,288,690.00	38,213,210.00	35.8
Шуудан холбоо, интернэтийн төлбөр	4,310,700.00	2,441,220.00	1,869,480.00	56.6
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	12,247,900.00	6,844,900.00	5,403,000.00	55.9
Нормативт зардал	200,019,700.00	126,906,379.20	73,113,320.80	63.4
Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	149,397,000.00	110,065,539.20	39,331,460.80	73.7
Хоол, хүнс	50,622,700.00	16,840,840.00	33,781,860.00	33.3
Эд хогшил худалдан авах	172,758,500.00	162,899,413.00	9,859,087.00	94.3
Багаж, техник, хэрэгсэл	73,820,000.00	72,155,900.00	1,664,100.00	97.7
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	7,000,000.00	6,090,000.00	910,000.00	87.0
Урсгал засвар	91,938,500.00	84,653,513.00	7,284,987.00	92.1
Томилолт, зочны зардал	6,000,000.00	2,724,800.00	3,275,200.00	45.4
Дотоод албан томилолт	6,000,000.00	2,724,800.00	3,275,200.00	45.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	3,886,000.00	3,729,598.00	156,402.00	96.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,500,000.00	2,457,000.00	43,000.00	98.3
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	576,000.00	576,000.00	-	100.0
Даатгалын үйлчилгээ	130,000.00	130,000.00	-	100.0

**Төв аймгийн Батсүмбэр сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан**

Тээврийн хэрэгслийн оношилгоо	80,000.00	80,000.00	-	100.0
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	600,000.00	486,598.00	113,402.00	81.1
Бараа үйлчилгээний бусад зардал	71,240,000.00	11,712,780.00	59,527,220.00	16.4
Бараа үйлчилгээний бусад зардал	71,240,000.00	11,712,780.00	59,527,220.00	16.4
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,716,975,400.00</b>	<b>1,220,656,557.39</b>	<b>496,318,842.61</b>	<b>71.1</b>
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>77,528,100.00</b>	<b>77,528,100.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
Орон нутгийн төсвөөс	77,528,100.00	77,528,100.00	-	100.0
<b>НД-ЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,637,447,300.00</b>	<b>1,140,586,057.39</b>	<b>496,861,242.61</b>	<b>69.7</b>
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,637,447,300.00	1,140,586,057.39	496,861,242.61	69.7
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>2,000,000.00</b>	<b>2,542,400.00</b>	<b>(542,400.00)</b>	<b>127.1</b>
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,000,000.00	2,542,400.00	(542,400.00)	127.1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	242,319,899.40	(242,319,899.40)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	142,799,792.17	(142,799,792.17)	-
<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>34</b>	<b>28</b>	<b>6</b>	<b>82.4</b>
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	25	19	6	76.0
Үйлчлэх ажилтан	8	8	-	100.0
<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО</b>	<b>14,469</b>	<b>14,469</b>	<b>-</b>	<b>100.0</b>
Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо	566	566	-	100.0
Улсын эмнэлгийн амбулатороор эмчлүүлэгсдийн тоо	13,903	13,903	-	100.0

**3. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

**3.1** Аудитаар нийт 1,427,164.1 мянган төгрөгийн 6 алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 1,427,164.1 мянган төгрөгийн 5 алдааг залруулж, 1 зөвлөмж өглөө.

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Нэмэлт санхүүжилтийн орлогоор тайлагнасан 2,000.0 мянган төгрөгийн орлогын тайланг бэлтгэж ирүүлээгүй.	1	2,000.0	1	2,000.0			1	2,000.0				
Нэг иргэнээр тооцсон болон гүйцэтгэлийн санхүүжилтийн нийт 1,412,138.1 мянган төгрөгийн орлогын сар бүрийн нэхэмжлэх, тооцоо нийлсэн акт зэргийг аудит ирүүлээгүй, санхүүгийн баримтад хавсаргаагүй байна	1	1,412,138.1	1	1,412,138.1			1	1,412,138.1				
Төсвийн гүйцэтгэлийн тайланд эмчлүүлэгчдийн тоог өмнөх он болон тайлант оноор тайлагнаагүй байна.	1		1				1					
Шалгагдагч байгууллага нь Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 04113-А/583/2022 тоот захирамжийн дагуу 4112045955 нэгж талбарын дугаартай 13,000.0 мянган төгрөгийн суурь үнэтэй газрыг нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй байна.	1	13,000.0	1	13,000.0			1	13,000.0				
Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 146 нэр төрлийн нийт 274,797.6 мянган төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгийг	1	-							1	-	1	-

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Төв аймгийн Батсүмбэр сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан

бодит үнэ цэнээр бүртгэж тайлагнаагүй байна.												
Тайлант онд нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 26.0 мянган төгрөгийг бүртгээгүй байна.	1	26.0	1	26.0			1	26.0				
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>1,427,164.1</b>	<b>5</b>	<b>1,427,164.1</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>5</b>	<b>1,427,164.1</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>-</b>

3.2 Аудитаар нийт 17,614.7 мянган төгрөгийн 7 зөрчил илэрснээс, 872.9 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт хүргүүлж, 16,741.9 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 5 зөвлөмж өглөө.

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Худалдан авсан хөрөнгө, материалын дүн нь бэлтгэн нийлүүлэгч байгууллагын төлбөрийн цахим системд бүртгэсэн төлбөрийн цахим баримтын дүнгээс 3 иргэн байгууллагын 61,611.5 мянган төгрөгөөр илүү, 18 иргэн, байгууллагын дүнг 182,148.0 мянган төгрөгөөр дутуу дүнгээр бүртгэгдсэн байна.	1	-					1	-				
Төлбөрийн цахим баримтын цахим системийн нэхэмжлэх дээр 21 байгууллагын 83,886.4 мянган төгрөгийн үлдэгдлийг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй байна.	1	-					1	-				
Эрүүл мэнд даатгалын ерөнхий газартай сар бүр тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулсан боловч ЭМДЕГ-аас 7-12 саруудын санхүүжилтийг олгоогүйн улмаас төлбөртэй үйлчилгээний авлага 296,766.6 мянган төгрөгт хүрч оны эхнээс 271,551.1 мянган төгрөгөөр буюу 11.8 дахин өссөн байна.	1	-					1	-				

Төв аймгийн Батсүмбэр сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан

Шалгагдагч байгууллагын нэхэмжилсэн нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний баримтыг ЭМДЕГ-аас шалган баталгаажуулж, нийт 16,095.6 мянган төгрөгийн зөрчилтэй үйлчилгээний төлбөрийг хасаж санхүүжүүлсэн байна.	1	-					1	-				
Шалгагдагч байгууллага нь 2018 онд батлагдсан НБББББ-ийг мөрдөж байна.	1	-					1	-				
Өмнөх оноос он дамжсан их засварын үлдэгдлээр тайлагнасан харилцагчийн нэр, зориулалт тодорхойгүй, 46,664.0 мянган төгрөгийн үлдэгдлээс 16,741.9 мянган төгрөгийн ажлыг гүйцэтгээгүй хугацаа хэтэрсэн байна.	1	16,741.9		1	16,741.9							
Тайлант онд 2 ажилтанд ээлжийн амралтын тооцоог 872.9 мянган төгрөгөөр илүү бодож олгосон байна.	1	872.9	1	872.9								
<b>Дүн</b>	<b>7</b>	<b>17,614.7</b>	<b>1</b>	<b>872.9</b>	<b>1</b>	<b>16,741.9</b>	<b>5</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>

**3.3 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.**

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 1 зөрчил илэрснээс 1 зөвлөмж өглөө.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

*/мянган төгрөгөөр/*

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>						
Тайлант оны шилэн дансны цахим хуудсыг шалгахад нийт 171 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлсэн 163, хугацаа хоцорч мэдээлсэн 2, хүлээгдэж байгаа 6 мэдээлэл байна. Шилэн дансанд мэдээлсэн 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого, зарлагын гүйлгээг Мөнгөн гүйлгээний журналын орлого, зарлагын дүнтэй тулгахад тохирч байна.	1		-	-	1	-
<b>Дүн</b>	<b>1</b>		<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>